



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/216

Сүхбаатар сум

“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, “в”, “л”, 39 дүгээр зүйлийн 39.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.3, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 163 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах, орон нутагт үйлдэгдэж байгаа зам тээврийн осол, хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгах зорилго бүхий “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” аяныг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Олон улсын болон улсын, орон нутгийн чанартай авто замын хөдөлгөөнд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, “Яараад яахав дээ” нөлөөллийн арга хэмжээг иргэд, олон нийтийг хамруулан аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/-үүрэг болгосугай.

3. “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд “Яараад яахав дээ” аяныг аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ